

“Алтан жолоо говь” ХК-ийн хувьцааг
үнэт цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалт болон “Алтан жолоо говь” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2008 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Алтан жолоо говь ” ХК-ийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар (Х.Бум-Эрдэнэ)-т, Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК (Р.Содхүү)-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Т.Гандулам)-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Компаниас хувь нийлүүлэгчидтэй хийх тооцоог 2008 оны 3 дугаар улиралд багтаан дуусгаж тайланг Хороонд ирүүлэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Т.Гандулам)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын талаар Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэж нийтэд мэдээлэхийг Тамгын газар (Н.Удаанжаргал)-д, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар (Х.Бум-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН